



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 07 сарын 28 өдөр

Дугаар А/492

Арвайхээр сум

Тусгай зориулалтын агнуурын амьтныг агнах
гэрээ байгуулах, эрх олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Зөвшөөрлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2.1.1, Амьтны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5.1, 29¹ дүгээр зүйлийн 29¹.7, Засгийн газрын 2022 оны “Тусгай зориулалтаар 2023 онд агнах, барих агнуурын амьтны тоо толгойг тогтоох тухай” 444 дүгээр тогтоол, 2023 оны “Амьтны экологи эдийн засгийн үнэлгээг шинэчлэн батлах тухай” 260 дугаар тогтоол, 2023 оны “Босго үнийн хэмжээ тогтоох тухай” 261 дүгээр тогтоол, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2023 оны “Хуваарь батлах тухай” А/215 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Өвөрхангай аймгийн хэмжээнд тусгай зориулалтаар агнуурын амьтныг агнах, зөвшөөрөл олгох дахин дуудлага худалдааны нэр бүхий ялагчдын жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2.Тусгай зориулалтын агнуурын амьтныг агнах зөвшөөрөл олгох дуудлага худалдааны нэр бүхий ялагчтай “Агнуурын амьтныг агнах, барих” гэрээ байгуулж, тусгай зориулалтын агнуурын амьтныг агнах зөвшөөрлийн үнэ, төлбөр хураамжийг хуульд заасан хугацаанд, холбогдох дансанд төвлөрүүлж, дуудлага худалдааны ялагч нарт тусгай зөвшөөрөл олгох ажлыг зохион байгуулж ажиллахыг аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Байгаль орчин, аялал жуулчлалын газар (Г.Баясгаланд)-т үүрэг болгосугай.

3.Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ц.Идэрсайханд)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

6723 11 0976

D:My Doc. Zahiramj. Zasag darga

Аймгийн Засаг даргын 2023 оны 07 дугаар
сарын 28-ны өдрийн 397/2023 дугаар
захирамжийн хавсралт



ТУСГАЙ ЗОРИУЛАЛТААР АГНУУРЫН АМЬТНЫГ АГНАХ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ
ДУУДЛАГА ХУДАЛДААНД ЯЛАГЧДЫН МЭДЭЭЛЭЛ

№	Ялагч байгууллагын нэр	Амьтны зүйлийн нэр	Дуудлага худалдаа	тоо толгой (ширхэг)	Экологи эдийн засгийн үнэлгээ (төгрөг)	Дэнчин үнэ (төгрөг)	Босго үнэ (төгрөг)	Төлвөл зохих Мөнгөн дүн (төгрөг)	Олзворын жишиг үнэ (доллар)	Төлбөр (доллар)	Хураамж (доллар)
									Тайлбар: Тухайн өдрийн Монгол банкнаас зарласан валютын ханшаар тооцдог		
1	Атон-Аммон ХХК	Халиун буга	Халиун буга 2	1	12,700,000	254,000	2,540,000 0	3,060,000	1600,0	1280,0	320,0
2	Атон-Аммон ХХК	Халиун буга	Халиун буга 3	1	12,700,000	254,000	2,540,000 0	3,054,000	1600,0	1280,0	320,0
НИИТ ДҮН								6,114.000	-	2,560.0	640.0